



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/53

Аргатай

Эзэмшил газрын хэмжээ
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус сумын Аргатай 3 дугаар багийн төв 7 дугаар гудамжны 700 тоотод байршилтай Соёлын төвийн эзэмшиж байгаа 1650 м² газрын хэмжээг шинээр барилга барихтай холбогдуулан 1953 м² болгон өөрчилж 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

Хоёр. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулахыг Газрын даамал (Т.Шуухааз)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/45 тоот захирамжинд дурьдсан Соёлын төвийн эзэмшиж байгаа 1650 м² газрын хэмжээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Т.ЦЭВЭЛМАА